# АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛЭХ “АЛСЫН ХАРАА - 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

/2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар/

2024.08.21 Улаанбаатар хот

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Ашигт малтмал, газрын тосны газрын хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар явцын хяналт-шинжилгээ хийж, зорилт, арга хэмжээний хэрэгжилт төлөвлөсөн түвшинд хүрч байгаа эсэхэд үнэлэлт өгч, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

## Хоёр. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Ашигт малтмал, газрын тосны газрын хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлж, дүгнэх шалгуурыг үндэс болгов.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Ашигт малтмал, газрын тосны газраас 4 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллахаар төлөвлөгдсөн бөгөөд хэрэгжилт нь 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа 1 /90 хувь/, зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа 2 /70 хувь/, тухайн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн 1 /50 хувь/ гэж тус тус үнэлэгдлээ.

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөгөөнд тусгагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хамаарах чиг үүрэг бүхий арга хэмжээнүүдийг хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамруулаагүй болно.

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Ашигт малтмал, газрын тосны газрын хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1.

| д/д | Арга хэмжээний нэр | Үнэлгээ | | | | | | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100% | 90% | 70% | 50% | 30% | 0% | |
| 1 | 4.2.11. Уул уурхайн салбарыг байгальд хал багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ. | | √ | | | | | 90% |
| 2 | 4.2.12. Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чанд мөрдөнө. | | | | √ | | | 50% |
| 3 | 4.2.14. Уул уурхайн ордыг ашиглалтад оруулж, өндөр технологийн хүнд үйлдвэрийн дараах цогцолборуудыг барьж, байгуулна.Үүнд: Уул уурхайн ордууд: ... | | | √ | | | | 70% |
| 4 | 4.2.24. Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ. | | | √ | | | | 70% |
| **Нийт үнэлгээ** | | | | | | | | **70%** |

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар **70.0** хувиар үнэлэгдсэн.

Тайлант хугацаанд “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөгөөний 4.2.11 дугаартай “Уул уурхайн салбарыг байгальд хал багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ” гэсэн арга хэмжээний хүрээнд “08 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 2023 оны 285 уулын ажлын тайлан ирснээс 62 тайлан баталгаажсан байна. Техникийн нөхөн сэргээлтийг 262.3 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 251.8 га талбайд, дүйцүүлэн хамгаалах ажлыг 151,0 га талбайд, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 572.7 га талбайд 11.5 сая мод тарьсан байна.” гэж тайлагнасан нь шалгуур үзүүлэлт, зорилтод түвшиндээ бүрэн хүрч, үр дүн гарсан байна.

Тус бодлогын баримт бичгийн 4.2.24 дугаартай “Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ” гэсэн арга хэмжээний хүрээнд “Ашигт малтмалын хайгуулын ажлын төлөвлөгөө 2024 онд 1227 ирүүлсэн, үүнээс 976 хайгуулын тусгай зөвшөөрөл дээр хийгдэх хайгуулын ажлын төлөвлөгөө, ашиглалтын тусгай зөвшөөрөл дээр хийгдэх 251 хайгуулын ажлын төлөвлөгөө, 2023 оны хайгуулын ажлын нийт 1047 ирүүлсэн тайлан байна.
Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нөөц хэлэлцүүлэхээр ирүүлсэн 89 хайгуулын ажлын үр дүнгийн 78 тайлан хэлэлцэж, үүнээс 65 тайлан хүлээн авсан, 13 тайлан буцаасан байна.” гэж тайлагнасан нь гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлсэн байна.

Мөн дээрх бодлогын баримт бичгийн 4.2.12 дугаартай “Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг

чанд мөрдөнө” гэсэн арга хэмжээний хүрээнд “Монголросцветмет ТӨҮГ”-ийн MV-011722 тусгай зөвшөөрөлтэй Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайн 2022 оны уулын ажлын тайлан, 2023 оны уулын ажлын төлөвлөгөө, тайлан, 2024 оны уулын ажлын төлөвлөгөөтэй танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч албажуулж ажилласан.

“Салхитын мөнгөний ордын 2024 оны уулын ажлын төлөвлөгөө, 2023 оны уулын ажлын тайлантай танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч албажуулж ажилласан.” гэж тайлагнасан нь боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн байна.

## Дөрөв. Дүгнэлт

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан Ашигт малтмал, газрын тосны газарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Нэг. “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан Ашигт малтмал, газрын тосны газарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг **70.0** хувьтай үнэлэгдэв.

## Тав. Зөвлөмж

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан Ашигт малтмал, газрын тосны газарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Нэг. Хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээг эрчимжүүлж, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, тайлагналтад анхаарах.

Хоёр. “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг төлөвлөсөн хугацаа, зорилтот түвшиндээ хүрч байгаа эсэхэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Уул уурхайн хэлтэс, Ашигт малтмал хайгуулын хэлтсийн дарга нарт зөвлөмж болгож байна.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар**

## “АЛСЫН ХАРАА - 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАРТ ХАМААРАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024 он

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | 2024 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Дөрөв. ЭДИЙН ЗАСАГ | | | | | | | |
| 3 | 4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно. | 4.2.11. Уул уурхайн салбарыг байгальд хал багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ. | 2020 - 2050 | - | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна. | 2024 оны ашиглалтын үйл ажиллагааны албажсан төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийг 937.0 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 969.6 га талбайд, дүйцүүлэх хамгаалах ажлыг 118,414.9 га талбайд нөхөн сэргээлт хийхээр, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2024 онд 4,231.8 га талбайд 18.2 сая мод тарихаар тусгуулсан.<br>2024.08.01-ний өдрийн байдлаар 2023 оны 285 уулын ажлын тайлан ирснээс 62 тайлан баталгаажсан байна.<br>Техникийн нөхөн сэргээлтийг 262.3 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 251.8 га талбайд, дүйцүүлэн хамгаалах ажлыг 151,0 га талбайд, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 572.7 га талбайд 11.5 сая мод тарьсан байна. | 90% |
| 4 | | 4.2.12. Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чанд мөрдөнө. | 2020 - 2050 | | Шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлсэн байна. | 1. Салхитын мөнгөний ордын 2024 оны уулын ажлын төлөвлөгөө, 2023 оны уулын ажлын тайлантай танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч албажуулж ажилласан.<br>2. Монголросцветмет ТӨҮГ-ийн MV-011722 тусгай зөвшөөрөлтэй Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайн 2022 оны уулын ажлын тайлан, 2023 оны уулын ажлын төлөвлөгөө, тайлан, 2024 оны уулын ажлын төлөвлөгөөтэй танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч албажуулж ажилласан. | 50% |
| 6 | | 4.2.14. Уул уурхайн ордыг ашиглалтад оруулж, өндөр технологийн хүнд үйлдвэрийн дараах | 2020-2050 | | Шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлсэн байна. | 1. Үйл ажиллагаа явуулж байгаа стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын 2024 оны 10 уулын ажлын төлөвлөгөө, 2023 оны 9 тайланг хянан хүлээн авсан.<br>2. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс одоогоор Техник, эдийн засгийн үндэслэлийн 2 тодотголыг хэлэлцэж шийдвэрлүүллээ.<br>3. Баялгийн сангийн тухай хуулийн төслийн УИХ-р хэлэлцүүлэх | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | цогцолборуудыг барьж, байгуулна.Үүнд: Уул уурхайн ордууд: Таван толгойн нүүрсний орд; Оюутолгойн далд уурхай; Дорноговийн цахиурын орд; Цагаан суваргын орд; Хармагтайн орд; Литийн орд; Газрын ховор элементийн хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлнэ. Хүнд үйлдвэр: Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр; Нефть-химийн, кокс-химийн, металлургийн үйлдвэр; Нүүрс угаах үйлдвэр; Нүүрс-химийн, нүүрс-эрчим хүч, метан хийн үйлдвэрлэл, технологийн парк; Ган төмөрлөгийн үйлдвэр; | | | | ажлын хүрээнд УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар орсон Стратегийн ач холбогдол бүхий 16 орд, 2 дугаар хавсралтад орсон 39 ордын мэдээллийг бэлтгэж УУХҮЯ-нд хүргүүлсэн. | |

<table>
<tr><td></td><td></td><td>Жонш баяжуулах үйлдвэр;<br>Алт цэвэршүүлэх үйлдвэрийг тус тус барьж байгуулна.</td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>11</td><td></td><td>4.2.24. Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.</td><td>2020<br>2050</td><td>-</td><td>-</td><td>2024 онд ирүүлсэн ашигт малтмалын хайгуулын ажлын төлөвлөгөө 1227, үүнээс хайгуулын тусгай зөвшөөрөл дээр хийгдэх хайгуулын ажлын төлөвлөгөө 976, ашиглалтын тусгай зөвшөөрөл дээр хийгдэх хайгуулын ажлын төлөвлөгөө 251, 2023 оны хайгуулын ажлын ирүүлсэн тайлан нийт 1047 байна.<br>Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нөөц хэлэлцүүлэхээр ирүүлсэн 89 хайгуулын ажлын үр дүнгийн тайлангаас хэлэлцсэн 78 үүнээс хүлээн авсан 65 тайлан, буцаасан 13 байна.<br><br>УЛСЫН НЭГДСЭН САНД БҮРТГЭГДСЭН АШИГТ МАЛТМАЛЫН ОРД, НӨӨЦ<br>2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар
<table>
<tr><th rowspan="2">№</th><th rowspan="2">Ордын төрөл</th><th rowspan="2">Ордын тоо</th><th colspan="3">Нөөц</th></tr>
<tr><th>Хэмжих нэгж</th><th>хүдэр/шлих</th><th>металл</th></tr>
<tr><td></td><td>Алт (үндсэн)</td><td rowspan="5"></td><td>мян.тн/кг</td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td>Мөнгө</td><td>мян.тн/тн</td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td>Хар тугалга</td><td>мян.тн</td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td>Цайр</td><td>мян.тн</td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td>Зэс</td><td>мян.тн</td><td></td><td></td></tr>
<tr><td>2</td><td>Алт (шороо)</td><td>6</td><td>кг</td><td>472.64</td><td>422.90</td></tr>
<tr><td>3</td><td>Мөнгө</td><td rowspan="2"></td><td>мян.тн/тн</td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td>Алт</td><td>кг</td><td></td><td></td></tr>
<tr><td>4</td><td>Зэс</td><td></td><td>мян.тн/тн</td><td></td><td></td></tr>
</table></td><td>70%</td></tr>
</table>

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Алт | | кг | | |
| | Мөнгө | | тн | | |
| | Молибден | | мян.тн | | |
| 5 | Төмөр | 1 | мян.тн | 685.04 | 211.83 |
| | Төмөр | | мян.тн | | |
| | Цайр | | мян.тн | | |
| 6 | Холимог металл | | мян.тн | | |
| | Хар тугалга | | тн | | |
| | Цайр | | тн | | |
| | Мөнгө | | тн | | |
| 7 | Никель | | мян.тн/тн | | |
| | Зэс | | тн | | |
| | Кобальт | | тн | | |
| 8 | Гянтболд (үндсэн) | | мян.тн/тн | | |
| 9 | Манган | | мян.тн | | |
| 10 | Хайлуур жонш | 1 | мян.тн | 6,160.87 | 1,664.45 |
| 11 | Цайр холимог | | | | |
| | Цайр | | | | |
| | Хар тугалга | | | | |
| | Мөнгө | | | | |
| | Кадми | | | | |
| 12 | Уран | | | | |
| 13 | Нүүрс /чулууны үетэй/ | 3 | сая.тн | 7,216.25 | 7,710.97 |
| 14 | Шохойн чулуу | 2 | мян.тн/тн | | 27,924.99 |
| 15 | Барилгын чулуу /дайрга/ | 3 | мян.м3 | | 10,435.00 |
| 16 | Боржин | | мян.м3 | | |
| 17 | Өнгөлгөөний | 1 | мян.м3 | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чулуу | | | | 15,471.79 | |
| | | | | | | 18 | Бал чулуу | | мян.тн | | | |
| | | | | | | 19 | Гөлтгөнө | | мян.тн | | | |
| | | | | | | 20 | Шавар | | мян.м3 | | | |
| | | | | | | 21 | Элс хайрга | 1 | мян.м3 | | 1,485.52 | |
| | | | | | | 22 | Элс | 1 | мян.м3 | | 1,129.32 | |
| | | | | | | 23 | Элсэн чулуу | | мян.м3 | | | |
| | | | | | | 24 | Цеолит | | мян.тн | | | |
| | | | | | | 25 | Занар | | мян.м3 | | | |
| | | | | | | 26 | Гантиг | | | | | |
| | | | | | | 27 | Газрын тос | | сая.баррель | | | |
| | | | | | | 28 | Цагаан тугалга | | тн | | | |
| | | | | | | 29 | Лити | | мян.тн | | | |
| | | | | | | | Стронци | | мян.тн | | | |
| | | | | | | | Кали | | мян.тн | | | |
| | | | | | | 30 | Молибден | | мян.тн/тн | | | |
| | | | | | | 31 | Кварц | | мян.тн | | | |
| | | | | | | 32 | Цахиур | | мян.тн | | | |
| | | | | | | 33 | Базальт | 1 | мян.тн | | 12,251.49 | |
| **ДҮН** | | | | | | | | | | | | **70%** |

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР